

**МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САНГИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУРААНГУЙ**

Огноо: 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдөр
Хурал хуралдсан газар: Сангийн яамны хурлын танхим

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

Монголын Мянганы сорилтын сан /Монголын МСС/-ийн Удирдах зөвлөлийн ээлжит хурлаар дор дурдсан 10 асуудлыг хэлэлцэж, харгалзах шийдвэрийг батлав. Үүнд:

Нэгдүгээр асуудал. Монголын МСС-ийн Удирдах зөвлөлийн иргэний нийгэм, төрийн бус байгууллагыг төлөөлөх шинэ гишүүнийг батлав.

Хоёрдугаар асуудал. Монголын МСС-ийн 2023 оны 2 дугаар улирлын Санхүүжилтийн төлөвлөгөө батлав.

Гуравдугаар асуудал. Монголын МСС-ийн 2023.04.01-2024.03.31-ний хооронд хэрэгжүүлэх Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлав.

Дөрөвдүгээр асуудал. Барилгын салбарт жендэрийн тэгш байдлыг хангах зорилгоор БХБЯ болон Монголын МСС-ийн хооронд байгуулах Харилцан ойлголцлын санамж бичгийг батлав.

Тавдугаар асуудал. Монголын МСС-ийн Удирдах зөвлөлийн дэргэдэх Аудит, эрсдэлийн хорооны дүрмийг батлав.

Зургаадугаар асуудал. Монголын МСС-ийн Хүний нөөцийн бодлогын баримт бичиг-Хөдөлмөрийн дотоод журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийг танилцуулав.

Долоодугаар асуудал. Монголын МСС-ийн Хөдөлмөрийн гэрээний загварт оруулах нэмэлт, өөрчлөлтийг танилцуулав.

Наймдугаар асуудал. Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд гүйцэтгэсэн Хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзлийн судалгааны үр дүнг түгээх, Хэрэглэгчдийн төлбөрийн чадавхыг судлах зорилгоор Үндэсний статистикийн хороотой байгуулсан Хэрэгжүүлэгч байгууллагын гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг танилцуулав.

Есдүгээр асуудал. Монголын МСС-ийн Дотоод аудитын багийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.

Аравдугаар асуудал. Бусад асуудал.